



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

НҮБ-ЫН ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫН СУУРЬ ЗАРЧМУУД БУСАД УЛС, ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛЬД ТУСГАГДСАН БАЙДЛЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын захиалгаар гүйцэтгэв

Улаанбаатар хот
2017 оны 05 дугаар сар

НҮБ-ЫН ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫН СУУРЬ ЗАРЧМУУД БУСАД УЛС, ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛЬД ТУСГАГДСАН БАЙДЛЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА

Нэг. Шүүхийн бие даасан байдалтай холбоотой зарчмууд /1-7 дугаар зарчим/:

1. Шүүхийн хараат бус байдлыг төрөөс баталгаажуулж, тухайн улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжуудад тусган баталгаажуулж, засгийн газар болон түүний харъяа байгууллагууд шүүхийн хараат бус байдлыг хүндэтгэж, сахин биелүүлнэ.
2. Шүүх аливаа хэргийг алагчлалгүйгээр, хэний ч нөлөөнд авталгүйгээр, нотлох баримтад үндэслэн, хуульд нийцүүлэн, хууль бус нөлөөлөл, сэтгэл хөдлөл, дарамт шахалт, сүрдүүлэггүйгээр, шууд болон шууд бус хөндлөнгийн оролцоогүйгээр шийдвэрлэнэ.
3. Шүүх нь Хуульд заасан эрх мэдлийн хүрээнд шүүхийн шинж чанар бүхий аливаа асуудал мөн өөрийн хэм хэмжээнд байх бүхий л асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
4. Шүүн таслах үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, шүүгчийн гаргасан шийдвэрийг засварлах субъект байх ёсгүй. Энэ зарчим нь шүүхийн хяналтыг хэрэгжүүлэх, шүүх эрх мэдлийн эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу шийдвэрийг өөрчлөхөд хамаарахгүй.
5. Хүн бүр энгийн шүүх болон дагнасан шүүхээр хуулийн процедур журмын дагуу шийдвэрлүүлэх эрхтэй. Шүүх нь энгийн болон дагнасан шүүхийн эрх мэдэлд хамаарахгүй хуулийн процедур журмын дагуу хэргийг хянан шийдвэрлэж болохгүй.
6. Шүүхийн байгууллагын хараат бус байдлын талаарх үндсэн зарчим нь шүүхийн процессын ажиллагаа явуулахдаа талуудын эрхийг хүндэтгэн, эрх тэгш хандаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэн ажиллах үүргийг хүлээлгэнэ.
7. Гишүүн улсын үүрэг нь шүүх эрх мэдлийг чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрээр хангахад оршино.

Үндсэн хууль	Холбогдох зүйл заалт	
БНӨАУ, 1996	165 дугаар зүйлийн 1. 2, 3, 4 дэх хэсэг, 34 дүгээр зүйл	<p>165 дугаар зүйл:</p> <p>1. Бүгд найрамдах улсын шүүх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлнэ.</p> <p>2. Шүүх бие даасан байх бөгөөд зөвхөн Үндсэн хууль, бусад хуульд захирагдана. Шүүхэд аливаа этгээд нөлөөлөх ёсгүй.</p> <p>3. Шүүхийн үйл ажиллагаанд төрийн байгууллага, албан тушаалтан нөлөөлөхийг хориглоно.</p> <p>4. Хууль тогтоомж, бусад арга хэрэгслээр дамжуулан төрийн байгууллагууд шүүхэд туслах, шүүхийн бие даасан, шударга, хүртээмжтэй болон үр дүнтэй байдлыг хамгаалах ёстой.</p> <p>34 дүгээр зүйл:</p> <p>Хүн бүр аливаа маргааныг бие даасан шүүхээр хуулийн дагуу шийдвэрлүүлэх эрхтэй.</p> <p>6-р зарчим тусгагдаагүй.</p>
Египет, 2014	96, 97, 98, 184, 186, 188 дугаар зүйл	<p>96. Шүүхээр гэм буруутай нь нотлогдох хүртэл хэнийг ч гэм буруугүй гэж үзнэ. Гэм буруугийн асуудлаар шүүхийн шийдвэрийг давж заалдах журмыг хуулиар тогтооно. Төрийн зүгээс хохирогч, гэрч, яллагдагч, мэдээлэгчийг хамгаалах арга хэмжээг хуульд заасны дагуу авна.</p> <p>97. Нэхэмжлэл, гомдол гаргах нь бүх нийтийн хамгаалагдсан, зайлшгүй эрх юм. Төрөөс шүүхээр үйлчлүүлэх баталгааг бүрдүүлнэ. Шүүх эрх мэдлийг шүүхээс өөр байгууллага, шүүгчээс өөр албан тушаалтан хэрэгжүүлэхийг хориглоно.</p> <p>98. Өөрөө буюу төлөөлөгчөөрөө дамжуулан эрхээ хамгаалуулж болно. Хууль зүйн мэргэжлийн бие</p>

		<p>даасан байдал нь өөрийгөө хамгаалах эрхийн баталгаа болно. Төлбөрийн чадваргүй, эрхээ хамгаалж чадахгүй этгээдэд үзүүлэх хууль зүйн туслалцааг хуулиар зохицуулна.</p> <p>184. Шүүх эрх мэдлийн байгууллага бие даасан байх бөгөөд түүнийг бүх төрлийн шүүх хэрэгжүүлнэ. Шүүх хуулийн дагуу шийдвэр гаргах бөгөөд шүүхийн харъяаллыг хуулиар тогтооно. Шүүхэд хөндлөнгөөс хууль бусаар нөлөөлөх үйлдлийг гэмт хэрэгт тооцно.</p> <p>186. Шүүгч хараат бус байх бөгөөд түүнийг хуульд зааснаас бусад нөхцөлөөр огцруулахыг хориглоно. Шүүгчийг томилох, чөлөөлөх нөхцөл, журмыг хуулиар тогтооно. Хуулиар шүүгчийн сахилга, хариуцлагын асуудлыг нэгэн адил зохицуулна. Хуульд заасан шүүгчийн сонгон шалгаруулалт, хариуцлагатай холбоотой асуудлыг хариуцах байгууллага нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангаж ажиллах бөгөөд сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.</p> <p>188. Шүүх эрх мэдлийн өөр байгууллагад харьяалуулснаас бусад бүх төрлийн маргаан, гэмт хэргийг шүүх хянан шийдвэрлэнэ. Шүүхийн өөрийн 50 гишүүнтэй холбоотой маргааныг зөвхөн шүүх харьяалан шийдвэрлэнэ. Шүүхийн үйл ажиллагааны асуудлыг Дээд зөвлөл хариуцах бөгөөд түүний бүтэц, харьяаллыг хуулиар тогтооно.</p> <p>6, 7-р зарчмууд тусгагдаагүй</p>
Хорват, 1991	118 дугаар зүйл	<p>14. Хорватын бүгд найрамдах улсын бүх хүн арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, үндэс угсаа, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, боловсрол, нийгмийн байдал, бусад онцлогоос үл хамааран эрх, эрх чөлөөг эдэлнэ. Бүх хүн хуулийн өмнө эрх тэгш байна.</p> <p>29. Хүн бүр хуулийн дагуу байгуулагдсан, бие даасан, шударга шүүхийн өмнө зохих хугацаанд хэргээ шударгаар шийдвэрлүүлэх, эрх, үүргээ мэдэх эрхтэй.</p> <p>Эрүүгийн хэрэгт сэжиглэгдэж, яллагдаж буй этгээдийн хувьд дараах эрхтэй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Өөрийн ойлгох хэлээр өөрийг нь буруутгаж буй эрүүгийн хэрэг, нотлох баримттай холбоотой тодорхой мэдээллийг нэн даруй авах, - Өөрийгөө хамгаалахад бэлтгэх зохих хугацаа, боломжтой байх, - Өмгөөлөгч авах, өмгөөлөгчтэй чөлөөтэй харилцах, - Өөрийн үгээр өөрийгөө бие даан хамгаалах буюу өөрийн сонголтоор өмгөөлөгчийн туслалцаа авах, өмгөөлөгч авах чадваргүй бол хуульд заасан нөхцөлийн дагуу төлбөргүйгээр өмгөөлөгч авах, - Шүүх хуралд биечлэн оролцох, - Гэрчийг байцаах буюу тийн байцаах үйл ажиллагааг зохион байгуулах, хамгаалах талын гэрчээс оролцуулах, асуулт асуухыг шаардах, - Шүүхийн албан ёсны хэлийг ойлгохгүй бол төлбөргүйгээр орчуулагчийн туслалцаа авах. <p>Шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй үед хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэхгүй. Хууль бусаар олж авсан нотлох баримтыг шүүн таслах үйл ажиллагаанд авч үзэхгүй. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг зөвхөн эрх бүхий прокурорын шүүхэд гаргасан хүсэлтээр явуулна.</p> <p>118. Шүүх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлнэ. Шүүх эрх мэдэл бие даасан, хараат бус байна. Шүүх нь Үндсэн хууль, олон улсын гэрээ болон хүчин төгөлдөр бусад эрх зүйн эх сурвалжийн дагуу шударга ёсыг сахиулна.</p> <p>4, 6-р зарчмууд тусгагдаагүй.</p>
Бүгд	81,82 дугаар	81 дүгээр зүйл:

<p>Найрамдах Чех Улс 1993</p>	<p>зүйлийн 1 дэх хэсэг, 85 дугаар зүйлийн 2 дах хэсэг, 96 дугаар зүйлийн 1 дэх хэсэг</p>	<p>Бие даасан шүүхүүд шүүх эрх мэдлийг Бүгд Найрамдах Улсын өмнөөс хэрэгжүүлнэ.</p> <p>82 дугаар зүйл: 1. Шүүгч үүргээ гүйцэтгэхдээ бие даасан байх ёстой. Шүүгчийн хараат бус байдалд хэн ч аюул учруулж болохгүй.</p> <p>85 дугаар зүйл: 2. Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь дараах албан үүргийн тангараг өргөнө: “Би өөрийн нэр төр, үзэл санааны дагуу Үндсэн хуулийн акт, журмыг дагаж мөрдөн бие даан хараат бус байдлаар өөрийн дотоод итгэл үнэмшлээр шийдвэр гаргах ба хүний жам ёсны болон иргэдийн эрхийн халдашгүй байдлыг хамгаална гэдгээ тангаргалаж байна.”</p> <p>96 дугаар зүйл: 1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч бүх талууд нь шүүхийн өмнө эрх тэгш байна.</p> <p>4, 6, 7-р зарчмууд тусгагдаагүй</p>
<p>Этиоп 1994</p>	<p>37 дугаар зүйл, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 79, 80 дугаар зүйл</p>	<p>37 дугаар зүйл: 1. Хүн бүр шүүхээр шийдвэрлүүлбэл зохих хэргээ шүүхэд буюу холбогдох хэрэг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх эрхтэй.</p> <p>78 дугаар зүйл: 1. Энэ Үндсэн хуульд заасны дагуу хараат бус, бие даасан шүүхийг байгуулна.</p> <p>79 дүгээр зүйл: 1. Шүүх эрх мэдэл нь Холбооны болон мужийн шүүхэд харьяалагдана. 2. Бүх шатны шүүхүүд нь засгийн газрын харьяа байгууллага, албан тушаалтан, өөр бусад эх сурвалжийн хөндлөнгийн оролцоо, нөлөөллөөс ангид байна. 3. Шүүгч өөрийн ажил, үүргийг хэрэгжүүлэхдээ бүрэн бие даасан байдлаар зөвхөн хуульд захирагдан ажиллана. 4. Шүүгч нь хуульд заасан тэтгэврийн насанд хүрснээр түүнийг ажлаас чөлөөлж болно. Дараах үндэслэлээс бусад тохиолдолд шүүгчийг ажлаас чөлөөлж болохгүй. 4.1. Шүүгч бүрэн бус бөгөөд хүчин төгөлдөр бус шийдвэр гаргасан, сахилгын дүрмийг зөрчсөн гэж Шүүхийн захиргааны зөвлөл шийдвэрлэсэн тохиолдолд; 4.2. Шүүхийн захиргааны зөвлөл шүүгчийг өвчний улмаас өөрийн ажил үүргийг гүйцэтгэх боломжгүй болсон хэмээн шийдвэрлэсэн тохиолдолд; 4.3. Ардын Төлөөлөгчдийн хурал болон мужийн зөвлөлөөс Шүүхийн захиргааны зөвлөлийн шийдвэрийг олонхоор дэмжсэн тохиолдолд. 5. Шүүгчийн тэтгэвэрт гарах насыг хуульд зааснаас бусад тохиолдолд нэмж болохгүй. 6. Холбооны Дээд шүүх нь Холбооны шүүхийн төсвийг тооцон Ардын төлөөлөгчдийн хуралд батлуулахаар шилжүүлэх бөгөөд төсвийг батлуулснаар захиран зарцуулна. 7. Мужийн шүүхийн төсвийг холбогдох мужийн зөвлөлөөс тогтооно. Дээд болон давж заалдах шатны шүүх нь холбооны давж заалдах болон холбооны анхан шатны шүүхийн эрх хэмжээг тус тус хэрэгжүүлдэг мужид Ардын төлөөлөгчдийн хурал нь нөхөн олговрын төсөв олгоно.</p> <p>80 дугаар зүйл: 1.Холбооны Дээд шүүх нь улсын хэмжээний хэрэгт эцсийн бөгөөд дээд шатны шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байна.</p>

		<p>2. Мужийн Дээд шүүх нь мужийн хэмжээний хэрэгт эцсийн бөгөөд дээд шатны шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байна. Мөн дээрх шүүх нь Холбооны давж заалдах шатны шүүхийн адил эрх мэдлийг хэрэгжүүлнэ.</p> <p>Тус зүйлийн 1, 2 дахь хэсэгт хамаарахгүй байх тохиолдол нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Холбооны Дээд шүүх нь бусад шатны шүүхийн хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй байна. Хүчингүй болгох үндэслэлийг хуулиар тогтооно. 2. Мужийн Дээд шүүх нь мужийн хэрэгт хамаарах бусад шатны шүүхийн хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй байна. Хүчингүй болгох үндэслэлийг хуулиар тогтооно. <p>3. Мужийн давж заалдах шатны шүүх нь мужийн шүүх эрх мэдлийн хүрээнд холбооны анхан шатны шүүхийн эрх мэдлийг хэрэгжүүлнэ.</p> <p>4. Холбооны анхан шатны шүүхийн эрх мэдлийг хэрэгжүүлсэн Мужийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг Улсын дээд шүүхэд давж заалдана.</p> <p>5. Холбооны асуудлаар гаргасан Мужийн дээд шүүхийн шийдвэрийг Холбооны Дээд шүүхэд давж заалдана.</p> <p>6, 7-р зарчмууд тусгагдаагүй.</p>
<p>Украин 1996</p>	<p>55, 62, 124, 126, 129, 130 дугаар зүйл</p>	<p>55 дугаар зүйл:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүний эрх, иргэдийн эрх, эрх чөлөө шүүхээр хамгаалагдсан байна. 2. Хүн бүр орон нутгийн өөрөө удирдах байгууллагын, төрийн эрх мэдлийн байгууллагын албан тушаалтан болон албан хаагч нарын үйлдэл, эс үйлдэхүйг эс зөвшөөрөх, шүүгчийг татгалзан гаргах эрхтэй. 3. Хүн бүр эрхээ хамгаалахаар Украины Дээд Радагийн Хүний эрхийн төлөөлөгч болох эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй. 4. Хүн бүр эрх, эрх чөлөөгөө хамгаалах дотоодын хууль эрх зүйн бүх аргыг хэрэглэсний дараа Украин улсын зөвшөөрч нэгдэн орсон олон улсын шүүхийн байгууллагад болон олон улсын бусад холбогдох байгууллагад гомдол гаргах эрхтэй. 5. Хүн бүр аливаа зөрчил, хууль бус халдлагаас хуулиар хориглоогүй арга хэлбэрээр өөрийгөө хамгаалах эрхтэй. <p>62 дугаар зүйл:</p> <ol style="list-style-type: none"> 1. Гэм буруутай болохыг шүүх эцэслэн тогтоогоогүй байхад хүнийг гэм буруутайд тооцож ял, шийтгэл хүлээлгэхийг хориглоно. 2. Гэмт хэрэгт буруутгагдсан хэн ч өөрийн гэм буруугүйг нотлох үүрэг хүлээх ёсгүй. 3. Хууль бусаар олж авсан нотлох баримт болон таамаглалд үндэслэж ял оногдуулж болохгүй. Гэм буруугүйн талаарх эргэлзээг буруутгагдаж буй хүнд ашигтайгаар тайлбарлана. 4. Шударга бус буюу үндэслэлгүй ял шийтгэл оногдуулсныг шүүх тогтоовол тухайн этгээдэд учирсан эдийн болон эдийн бус хохирлыг төр хариуцна. <p>124 дүгээр зүйл:</p> <p>Украинд шударга ёсыг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. Шүүхийн шүүн таслах ажиллагааг бусад байгууллага эсхүл албан тушаалтан хэрэгжүүлэхийг хориглоно.</p> <p>Шүүхийн харьяалал нийт нутаг дэвсгэрийн бүхий л хууль эрх зүйн харилцаанд үйлчилнэ.</p> <p>Шүүн таслах ажиллагааг Үндсэн хуулийн шүүх болон бусад ердийн шүүхүүд хэрэгжүүлнэ.</p>

	<p>Шүүн таслах ажиллагаанд ард түмнээс зөвлөх болон иргэдийн төлөөлөгч оролцуулна. Шүүхийн шийдвэрийг Украин Улсын нэрийн өмнөөс гаргах бөгөөд Украины нийт нутаг дэвсгэрт үйлчилнэ.</p> <p>126 дугаар зүйл:</p> <p>Шүүгчийн хараат бус, халдашгүй байдал нь Үндсэн хууль болон бусад хуулиар хамгаалагдсан байна. Шүүгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.</p> <p>Шүүхээс гэм буруутай болохыг тогтоосон шийдвэр гартал Украины Дээд Радагийн (Парламент) зөвшөөрөлгүйгээр шүүгчийг саатуулах болон баривчлахыг хориглоно.</p> <p>Анх удаа томилогдсон шүүгч болон Украины Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид, хязгааргүй хугацаагаар шүүгчийн албан тушаалд томилогдоно.</p> <p>Дараах тохиолдолд шүүгчийг томилсон байгууллага нь шүүгчийг албан тушаалаас нь огцруулна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none">1. сонгогдсон буюу томилогдсон хугацаа дуусгавар болсон;2. 65 нас хүрсэн бол;3. эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх чадваргүй болсон бол;4. шүүгчид тавигдах шаардлагыг зөрчсөн тохиолдолд;5. шүүгчийн тангараг зөрчсөн;6. гэм буруутай болохыг тогтоосон шүүхийн шийдвэр гарсан;7. харьяатаас гарах болсон;8. шүүгч сураггүй алга болсон, эсхүл түүнийг нас барсанд тооцсон тохиолдолд;9. албан тушаалаасаа сайн дураараа чөлөөлөх тухай мэдэгдэл хүргүүлсэн. <p>Шүүгчийн эрх мэдэл нь түүний нас барсан тохиолдолд дуусгавар болно.</p> <p>Төрөөс шүүгч болон шүүгчийн гэр бүлийн хувийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.</p> <p>129 дүгээр зүйл:</p> <p>Дээд шүүхийн шүүгч болон бусад шүүгчид хараат бус байж гагцхүү хуульд захирагдана.</p> <p>Шүүн таслах ажиллагааг шүүгч дангаар болон бүрэлдэхүүнээр, иргэдийн төлөөлөгчийг оролцуулан явуулна.</p> <p>Шүүн таслах ажиллагааны үндсэн зарчмууд:</p> <ol style="list-style-type: none">1. хууль ёсны байх;2. шүүн таслах ажиллагааны оролцогчид хуулийн дагуу шүүхийн өмнө тэгш эрхтэй байх;3. гэм буруутай нь нотлогдсон байна;4. талуудын мэтгэлцээний журмын дагуу шүүхэд нотлох баримтаа танилцуулж, нотлох баримт хөдөлшгүй болохыг батлах;5. Төрийн нэрийн өмнөөс улсын яллагч оролцож яллах;6. Яллагдагч өөрийгөө хамгаалах эрхээр хангагдсан байх;7. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах болон техник хэрэгслээр баримтжуулах;8. Хуульд өөрөөр заагаагүй бол давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрийн эсрэг давж заалдах эрхтэй байх;9. шүүхийн шийдвэрийг заавал дагаж мөрдөх. <p>Хуулиар онцгой харьяаллын шүүхийн шүүн таслах ажиллагааны бусад зарчмыг тодорхойлж болно.</p> <p>Шүүх болон шүүгчийг үл хүндэтгэсэн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.</p>
--	--

		<p>130 дугаар зүйл: Шүүгчийн үйл ажиллагаа, шүүхийн үйл ажиллагааны зохих нөхцөл болон санхүүжилтийг улс хангана. Шүүхийн засварын зардал Украин улсын төсөвт тусад нь хуваарилсан байна. Шүүгчийн хувийн зохион байгуулалт нь шүүхийн дотоод хэргийн асуудлыг шийдвэрлэхэд нөлөө үзүүлнэ. 4-р зарчим тусгагдаагүй.</p>
Унгар Улс 2011	25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйл	<p>25 дугаар зарчим 1. Шүүх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлнэ. Шүүхийн дээд байгууллага нь Курия байна.</p> <p>26 дугаар зүйл: 1.Шүүгч хараат бус байж хуульд захирагдан ажиллах бөгөөд шүүхийн үйл ажиллагаандаа бусдаас заавар, чиглэл авахгүй. Зөвхөн хуульд тусгайлан заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг чөлөөлж болно. Шүүгч улс төрийн нам, улс төрийн үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцохыг хориглоно.</p> <p>28 дугаар зүйл: Шүүх аливаа хууль хэрэглэхдээ Үндсэн хуулийн зорилгын дагуу аливаа анхдагч бичвэрийг тайлбарлана. Үндсэн хууль, бусад хуулийн тайлбар нь нийтийн ашиг сонирхлыг хангахад чиглэх бөгөөд ёс суртахууны болон эдийн засгийн зорилгод үндэслэсэн байна. 6, 7-р зарчмууд тусгагдаагүй.</p>
Бүгд найрамдах Вьетнам Улс	16 дугаар зүйлийн 1, 2 дах хэсэг, 103 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	<p>16 дугаар зүйл. 1.Хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байна. 2.Хэн ч өөрийн улс төр, иргэний болоод эдийн засаг, соёл, нийгмийн амьдралын байдлаас хамааран ялгаварлан гадуурхагдаж үл болно.</p> <p>103 дугаар зарчим 2. Шүүгч, ардын төлөөлөгч нь хараат бус, бие даан ажиллах бөгөөд зөвхөн хуульд захирагдана. Шүүгч, ардын төлөөлөгч нарт аливаа байгууллага, хуулийн этгээд, хувь хүн нөлөөлөхийг хориглоно. 3, 6, 7-р зарчмууд тусгагдаагүй.</p>

Хоёр. Шүүгчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй холбоотой /8, 9 дүгээр зарчим/:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглалын дагуу шүүхийн байгууллагын ажилчид, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч нь бусад иргэний адил үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх, цуглаан хийх эрхтэй ба энэхүү эрхээ эдэлж байгаа шүүгчид нь үргэлж албаны нэр төр, шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хадгална.
- Шүүгчийн мэргэжлийн сургалтыг дэмжих, шүүхийн хараат бус байдлыг хамгаалахын тулд, тэдний ашиг сонирхлыг төлөөлөх шүүгчдийн бүрэлдэхүүнтэй байгууллага болон бусад байгууллага, холбоонд нэгдэх эрхтэй.

Үндсэн хууль	Холбогдох зүйл заалт
БНӨАУ, 1996	Тусгагдаагүй
Египет, 2014	Тусгагдаагүй
Хорват, 1991	Тусгагдаагүй
Чех 1993	Тусгагдаагүй
Этиоп 1994	Тусгагдаагүй

Украин1996		Тусгагдаагүй
Унгар улс 2011		Тусгагдаагүй
Вьетнам улс		Тусгагдаагүй

Гурав. Шүүгчийн сонгон шалгаруулалт, сургалттай холбоотой /10 дугаар зарчим/

10. Шүүгчээр сонгогдсон этгээд хувь хүний хувьд шударга, зохих сургалтад хамрагдсан, хуульд заасан мэргэжлийн ур чадвартай байна. Шүүгч сонгон шалгаруулах аливаа арга нь буруу сэдэл, зорилгоор шүүгчийг томилохоос сэргийлсэн байна. Шүүгчийг сонгохдоо арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, яс үндэс, нийгмийн гарал байдал, өмч хөрөнгө, нийгмийн байдал зэрэг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах ёсгүй. Шүүгчид нэр дэвшигч нь тухайн улсын иргэн байх шаардлагыг ялгаварлан гадуурхсан гэж үзэхгүй.

Үндсэн хууль	Холбогдох зүйл заалт	
БНӨАУ, 1996	174 дүгээр зүйлийн 2 дах хэсэг	174 дүгээр зүйл: 2. Шүүгч, шүүхийн ажилтнуудыг томилоход арьс өнгө, хүйсийн тэнцвэрийг харгалзан үзнэ.
Египет, 2014		Тусгагдаагүй
Хорват, 1991		Тусгагдаагүй
Чех 1993	93 дугаар зүйлийн 2 дах хэсэг	93 дугаар зүйл: 2. Хууль зүйн дээд боловсролтой Чех улсын аливаа иргэн шүүгчээр томилогдож болно. Цаашдын мэргэшил болон үйл ажиллагааг дүрэмд заасан байх ёстой.
Этиоп 1994		Тусгагдаагүй
Украин1996	127 дугаар зүйл	127 дугаар зүйл: Мэргэжлийн шүүгчээс шударга ёсыг хэрэгжүүлэх бөгөөд хуульд заасан тохиолдолд иргэний үнэлэгч, төлөөлөгчдөөс хэрэгжүүлнэ. Мэргэжлийн шүүгч улс төрийн нам болон үйлдвэрчний эвлэлд харьяалагдах, улс төрийн үйл ажиллагаа эрхлэх, төлөөлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, багшлах болон судалгааны ажлаас бусад төлбөртэй ажил эрхлэхийг хориглоно. Хууль зүйн дээд боловсролтой, 3-аас доошгүй жил хуулийн салбарт ажилласан, 10-с доошгүй жил Украин улсад оршин сууж байгаа улсын хэл мэддэг Украин улсын 25 нас хүрсэн иргэнийг шүүгчийн албан тушаалд Шүүгчийн Мэргэшлийн Хорооноос санал болгож болно. Дагнасан шүүхийн харьяаллын асуудлаар мэргэжлийн сургалтад суусан хүмүүс эдгээр шүүхийн шүүгчид байж болно. Эдгээр шүүгчид зөвхөн шүүгчдийн зөвлөлийн гишүүний дагуу шударга байдлыг тогтооно. Тодорхой ангиллын шүүгчийн хувьд туршлага, нас, мэргэжлийн түвшинтэй хамааралтай нэмэлт шаардлагыг хуулиар тогтооно. Шүүгчдийн мэргэжлийн ашиг сонирхлыг зохицуулах асуудлыг хуулиар зохицуулна.
Унгар улс 2011		Тусгагдаагүй
Вьетнам улс		Тусгагдаагүй

Дөрөв. Шүүгчийн албаны бүрэн эрхийн баталгаатай холбоотой /11-14 дүгээр зарчим/

11. Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа, хараат бус, аюулгүй байдал, зохих цалин хөлс, ажлын нөхцөл, тэтгэвэрт гарах насыг хуулиар тусгайлан зохицуулна.
12. Шүүгч томилогдсон, сонгогдсон эсэхээс үл хамааран тэтгэвэрт гарах, бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэл шүүгчийн бүрэн эрхийн хугацаа баталгаатай байна.
13. Шүүгчийг дэмжих буюу дэвшүүлэх тогтолцоо нь бодит хүчин зүйл, эзэмшсэн байх ур чадвар, туршлагад суурилсан байх ёстой.
14. Тухайн шүүх дэх шүүгчдэд хэрэг хуваарилах үйл ажиллагаа нь шүүхийн захиргааны дотоод үйл ажиллагаа байна.

Үндсэн хууль	Холбогдох зүйл заалт	
БНӨАУ, 1996	176 дугаар зүйлийн 1, 2, 3 дах хэсэг	<p>176 дугаар зүйл: Бүрэн эрхийн хугацаа ба цалин хөлс</p> <p>1. Хуульд өөрөөр заагаагүй бол Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн бүрэн эрхийн хугацаа нэг удаа 12 жил байх бөгөөд энэ хугацаа болоогүй ч 70 насанд хүрсэн шүүгчийн бүрэн эрх дуусгавар болно.</p> <p>2. Бусад шүүхийн шүүгчийн хувьд түүний бүрэн эрх хуульд заасан тэтгэвэрт гарах хүртэл үйлчилнэ.</p> <p>3. Шүүгчийн цалин хөлс, тэтгэмж, бусад нэмэгдлийг бууруулахыг хориглоно.</p> <p>13, 14-р зарчмууд тусгагдаагүй</p>
Египет, 2014		Тусгагдаагүй
Хорват, 1991	123 дугаар зүйл	<p>123 дугаар зүйл:</p> <p>Шүүгчийг бүх насаар нь томилно. Шүүгчийг дараах үндэслэлээр албан тушаалаас нь чөлөөлнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Шүүгчийн өөрийн хүсэлт - Эрүүл мэндийн болон бусад хүндэтгэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон - Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, - Хуульд заасны дагуу сахилгын ноцтой зөрчил гаргасан гэж Үндэсний Шүүхийн зөвлөл шийдвэрлэсэн - 70 нас хүрсэн. <p>Шүүгчийг үндэслэлгүй чөлөөлсөн гэж үзвэл тухайн шүүгч тийнхүү шийдвэр гарснаас хойш 15 хоногийн дотор Үндсэн хуулийн шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй. Хорватын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн дагуу Үндсэн хуулийн шүүх нь хуульд заасан бүрэлдэхүүн, журмын дагуу давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэнэ.</p> <p>Шүүгчийг чөлөөлсөн тухай Үндэсний Шүүхийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл тухайн шүүгч тийнхүү шийдвэр гарснаас хойш 15 хоногийн дотор Үндсэн хуулийн шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй. Хорватын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн дагуу Үндсэн хуулийн шүүх нь хуульд заасан бүрэлдэхүүн, журмын дагуу давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэнэ.</p> <p>Дээр дурдсаны дагуу Үндсэн хуулийн шүүхээс 30 хоногийн дотор гомдлыг хянан үзэж шийдвэр гаргана. Уг асуудлаарх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхгүй.</p> <p>Хуульд заасны дагуу шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнөөс бусад тохиолдолд шүүгчийг дур мэдэн шилжүүлэхийг хориглоно.</p> <p>Шүүгч албан үүргээ гүйцэтгэх боломжгүй буюу чадваргүй болсон тохиолдолд шүүн таслах үйл ажиллагаа явуулахгүй.</p> <p>11, 13, 14-р зарчмууд тусгагдаагүй</p>

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн

<p>Чех 1993</p>	<p>82 дугаар зүйлийн 2 дах хэсэ, 93 дугаар зүйлийн 1 дэх хэсэг</p>	<p>82 дугаар зүйл: 2. Өөрийн хүсэл зоригоос гадуур шүүгчийг албан тушаалаас нь огцруулж эсвэл өөр шүүх рүү шилжүүлэхийг хориглоно. Ялангуяа сахилгын хариуцлагын үр дагавар нь дүрэмд заасан байх ёстой.</p> <p>93 дугаар зүйл: 1. Шүүгчийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч хугацаагүй томилно. Шүүгч тангараг өргөнө. 13, 14-р зарчмууд тусгагдаагүй</p>
<p>Этиоп 1994</p>	<p>79 дүгээр зүйл</p>	<p>79 дүгээр зүйл: 1. Шүүх эрх мэдэл нь Холбооны болон мужийн шүүхэд харьяалагдана. 2. Бүх шатны шүүхүүд нь засгийн газрын харьяа байгууллага, албан тушаалтан, өөр бусад эх сурвалжийн хөндлөнгийн оролцоо, нөлөөллөөс ангид байна. 3. Шүүгч өөрийн ажил, үүргийг хэрэгжүүлэхдээ бүрэн бие даасан байдлаар зөвхөн хуульд захирагдан ажиллана. 4. Шүүгч нь хуульд заасан тэтгэврийн насанд хүрснээр түүнийг ажлаас чөлөөлж болно. Дараах үндэслэлүүдээс бусад тохиолдолд шүүгчийн ажлаас чөлөөлж болохгүй. 4.1. Шүүгч бүрэн бус бөгөөд хүчин төгөлдөр бус шийдвэр гаргасан, сахилгын дүрмийг зөрчсөн гэж Шүүхийн захиргааны зөвлөл шийдвэрлэсэн тохиолдолд; 4.2. Шүүхийн захиргааны зөвлөл шүүгчийг өвчний улмаас өөрийн ажил үүргийг гүйцэтгэх боломжгүй болсон хэмээн шийдвэрлэсэн тохиолдолд; 4.3. Ардын Төлөөлөгчдийн хурал болон мужийн зөвлөлөөс Шүүхийн захиргааны зөвлөлийн шийдвэрийг олонхоор дэмжсэн тохиолдолд. 5. Шүүгчийн тэтгэвэрт гарах насыг хуульд зааснаас бусад тохиолдолд нэмж болохгүй. 6. Холбооны Дээд шүүх нь Холбооны шүүхийн төсвийг тооцон Ардын төлөөлөгчдийн хурлаар батлуулах бөгөөд батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулна. 7. Мужийн шүүхийн төсвийг холбогдох мужийн зөвлөлөөс тогтооно. Дээд болон давж заалдах шатны шүүх нь холбооны давж заалдах болон холбооны анхан шатны шүүхийн эрх хэмжээг тус тус хэрэгжүүлдэг мужид Ардын төлөөлөгчдийн хурал нь нөхөн олговрын төсөв олгох ёстой. 13, 14-р зарчмууд тусгагдаагүй</p>
<p>Украин 1996</p>	<p>126 дугаар зүйл</p>	<p>126 дугаар зүйл: Шүүгчийн хараат бус, халдашгүй байдал нь Үндсэн хууль болон бусад хуулиар хамгаалагдсан байна. Шүүгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно. Шүүхээс гэм буруутай болохыг тогтоосон шийдвэр гартал Украины Дээд Радагийн (Парламент) зөвшөөрөлгүйгээр шүүгчийг саатуулах болон баривчлахыг хориглоно. Анх удаа томилогдсон шүүгч болон Украины Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид, хязгааргүй хугацаагаар шүүгчийн албан тушаалд томилогдоно. Дараах тохиолдолд шүүгчийг томилсон байгууллага нь шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлөх эсхүл огцруулна. Үүнд: 1. сонгогдсон буюу томилогдсон хугацаа дуусгавар болсон; 2. 65 нас хүрсэн бол; 3. эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх чадваргүй болсон бол; 4. шүүгчид тавигдах шаардлагыг зөрчсөн тохиолдолд;</p>

		<p>5. шүүгчийн тангараг зөрчсөн; 6. гэм буруутай болохыг тогтоосон шүүхийн шийдвэр гарсан; 7. харьяатаас гарах болсон; 8. шүүгч сураггүй алга болсон, эсхүл түүнийг нас барсанд тооцсон тохиолдолд; 9. албан тушаалаасаа сайн дураараа чөлөөлөх тухай мэдэгдэл хүргүүлсэн. Шүүгчийн эрх мэдэл нь түүний нас барсан тохиолдолд дуусгавар болно. Төрөөс шүүгч болон шүүгчийн гэр бүлийн хувийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. 13, 14-р зарчмууд тусгагдаагүй.</p>
Унгар улс 2011	26 дугаар зүйл	<p>26 дугаар зүйл: 1. Шүүгч хараат бус байж хуульд захирагдан ажиллах бөгөөд шүүхийн үйл ажиллагаандаа бусдаас заавар, чиглэл авахгүй. Зөвхөн хуульд тусгайлан заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг чөлөөлж болно. Шүүгч улс төрийн нам, улс төрийн үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцохыг хориглоно. 12, 13, 14-р зарчим тусгагдаагүй</p>
Вьетнам улс	105 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	<p>105 дугаар зүйл: 3. Шүүгчийг сонгон шалгаруулах томилох, чөлөөлөх, огцруулах асуудлыг хуулиар зохицуулна. 12, 13, 14-р зарчим тусгагдаагүй.</p>

Тав. Мэргэжлийн нууцлал болон дархан эрх /15, 16-р зарчим/

15. Нээлттэй шүүх хуралдаанаас бусад шүүн таслах ажиллагааны хүрээнд албан үүргийн дагуу олж мэдсэн шүүхийн мэргэжлийн нууцыг задруулахыг хориглох бөгөөд тэрхүү нууцтай холбоотойгоор мэдүүлэг авахыг хориглоно.
16. Үндэсний хуульд заасны дагуу аливаа мэргэжлийн сахилгын үйл ажиллагаа, тухайн улсын нөхөн олговор олгох харилцааг хөндөхгүйгээр шүүгч нь шүүн таслах үйл ажиллагаа явуулсны төлөө мөнгөн хохиролтой холбоотой иргэний нэхэмжлэлээс халдашгүй дархан байна.

Үндсэн хууль		Холбогдох зүйл заалт
БНӨАУ, 1996		Тусгагдаагүй
Египет, 2014		Тусгагдаагүй
Хорват, 1991	122 дугаар зүйл	<p>122 дугаар зүйл: Шүүгч хуульд заасны дагуу дархан эрх эдэлнэ. Эрүүгийн гэмт хэрэгт хамаарахаас бусад тохиолдолд шүүх хуралдаанд оролцож байгаа шүүгч болон шүүхийн иргэдийн төлөөлөгч нь шүүхийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд үзэл бодлоо хэлэх, санал хураахыг хориглоно. Үндэсний шүүхийн зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр шүүгчийг шүүн таслах үйл ажиллагаатай нь холбогдуулан эрүүгийн хэрэгт мэдүүлэг авах, мөрдөн байцаахыг хориглоно. 15-р зарчим тусгагдаагүй</p>
Чех 1993		Тусгагдаагүй
Этиоп 1994		Тусгагдаагүй
Украин 1996		Тусгагдаагүй
Унгар улс 2011		Тусгагдаагүй
Вьетнам улс		Тусгагдаагүй

Зургаа. Сахилгын хариуцлага, шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулахтай холбоотой /17-20-р зарчим/

17. Шүүгчийн мэргэжлийн ур чадвартай холбоотойгоор түүний эсрэг аливаа хэрэг, гомдлын үйл ажиллагааг зохих ёсны процедурын дагуу шударгаар, шуурхай хянан хэлэлцэнэ. Шүүгч нь шударга сонсгол явуулахыг шаардах эрхтэй. Шүүгч өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд хянан шалгах анхдагч үйл ажиллагаа нь нууц байна.
18. Шүүгчийг мэргэжлийн болон зан байдлын хувьд өөрсдийн ажил үүргээ биелүүлж чадахгүй, ажилд тохирохгүй гэх шалтгаанаас өөр бусад шалтгаанар сахилгын шийтгэл оногдуулж, албан үүргээс нь чөлөөлж болохгүй.
19. Шүүгчийн сахилгын шийтгэл болон албанаас нь түдгэлзүүлэх, ажлаас халахтай холбогдсон ажиллагаа нь шүүхийн ёс зүйн тогтоосон стандартын дагуу явагдах ёстой.
20. Сахилгын шийтгэл болон албанаас нь түдгэлзүүлэх, ажлаас халах ажиллагаа нь тусгайлсан процедур, журмын дагуу явагдах ёстой. Энэхүү зарчим нь Дээд шүүх болон хууль тогтоох байгууллагын гишүүдийг огцруулах, бусад ижил төстэй ажиллагаанаас гарах шийдвэрт хамаарахгүй.

Үндсэн хууль	Холбогдох зүйл заалт	
БНӨАУ, 1996	177 дугаар зүйл	<p>177 дугаар зүйл</p> <p>1. Шүүгчийг зөвхөн дараах үндэслэлээр албан тушаалаас огцруулна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Шүүхийн албаны комиссоос шүүгчийг албан үүргээ гүйцэтгэх чадваргүй, чадамжгүй буюу ёс зүйн зөрчилтэй гэж үзсэн; • Үндэсний Ассамблейгаас түүний гишүүдийн 2/3-ын саналаар шүүгчийг огцруулах тухай тогтоол батлагдсан. <p>2. Шүүгчийг огцруулах тухай тогтоол батлагдмагц шүүгчийг Ерөнхийлөгч огцруулна.</p> <p>3. Ерөнхийлөгчийн зүгээс энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалтын дагуу Шүүхийн албаны комиссын зөвлөмжийн дагуу шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлж болно.</p> <p>17, 19, 20-р зарчмууд тусгагдаагүй</p>
Египет, 2014		Тусгагдаагүй
Хорват, 1991	123 дугаар зүйл	<p>123 дугаар зүйл:</p> <p>Шүүгчийг бүх насаар нь томилно. Шүүгчийг дараах үндэслэлээр албан тушаалаас нь чөлөөлнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Шүүгчийн өөрийн хүсэлт; - Эрүүл мэндийн болон бусад хүндэтгэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон; - Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн; - Хуульд заасны дагуу сахилгын ноцтой зөрчил гаргасан гэж Үндэсний Шүүхийн зөвлөл шийдвэрлэсэн; - 70 нас хүрсэн. <p>Шүүгчийг үндэслэлгүй чөлөөлсөн гэж үзвэл тухайн шүүгч тийнхүү шийдвэр гарснаас хойш 15 хоногийн дотор Үндсэн хуулийн шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй. Хорватын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн дагуу Үндсэн хуулийн шүүх нь хуульд заасан бүрэлдэхүүн, журмын дагуу давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэнэ.</p> <p>Шүүгч Үндэсний Шүүхийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл тухайн шүүгч тийнхүү шийдвэр гарснаас хойш 15 хоногийн дотор Үндсэн хуулийн шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй.</p> <p>Хорватын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн дагуу Үндсэн хуулийн шүүх нь хуульд заасан</p>

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн

		<p>бүрэлдэхүүн, журмын дагуу давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэнэ. Дээр дурдсаны дагуу Үндсэн хуулийн шүүхээс 30 хоногийн дотор гомдлыг хянан үзэж шийдвэр гаргана. Уг асуудлаарх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхгүй. Хуульд заасны дагуу шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнөөс бусад тохиолдолд шүүгчийг дур мэдэн шилжүүлэхийг хориглоно. Шүүгч албан үүргээ гүйцэтгэх боломжгүй буюу чадваргүй болсон тохиолдолд шүүн таслах үйл ажиллагаа явуулахгүй. 17-р зарчим тусгагдаагүй</p>
Чех 1993	82 дугаар зүйлийн 2 дах хэсэг	<p>82 дугаар зүйл: 2. Өөрийн хүсэл зоригоос гадуур шүүгчийг албан тушаалаас нь огцруулах эсвэл өөр шүүх рүү шилжүүлэхийг хориглоно. Ялангуяа сахилгын хариуцлагын үр дагавар нь дүрэмд заасан байх ёстой. 17, 19, 20-р зарчим тусгагдаагүй</p>
Этиоп 1994		Тусгагдаагүй
Украин 1996	126 дугаар зүйл	<p>126 дугаар зүйл: Шүүгчийн хараат бус, халдашгүй байдал нь Үндсэн хууль болон бусад хуулиар хамгаалагдсан байна. Шүүгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно. Шүүхээс гэм буруутай болохыг тогтоосон шийдвэр гартал Украины Дээд Радагийн (Парламент) зөвшөөрөлгүйгээр шүүгчийг саатуулах болон баривчлахыг хориглоно. Анх удаа томилогдсон шүүгч болон Украины Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид, хязгааргүй хугацаагаар шүүгчийн албан тушаалд томилогдоно. Дараах тохиолдолд шүүгчийг томилсон байгууллага нь шүүгчийг албан тушаалаас нь огцруулна. Үүнд: 1. сонгогдсон буюу томилогдсон хугацаа дуусгавар болсон; 2. 65 нас хүрсэн бол; 3. эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх чадваргүй болсон бол; 4. шүүгчид тавигдах шаардлагыг зөрчсөн тохиолдолд; 5. шүүгчийн тангараг зөрчсөн; 6. гэм буруутай болохыг тогтоосон шүүхийн шийдвэр гарсан; 7. харьяатаас гарах болсон; 8. шүүгч сураггүй алга болсон, эсхүл түүнийг нас барсанд тооцсон тохиолдолд; 9. албан тушаалаасаа сайн дураараа чөлөөлөх тухай мэдэгдэл хүргүүлсэн. Шүүгчийн эрх мэдэл нь түүнийг нас барсан тохиолдолд дуусгавар болно. Төрөөс шүүгч болон шүүгчийн гэр бүлийн хувийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. 17, 19, 20-р зарчим тусгагдаагүй</p>
Унгар улс 2011		Тусгагдаагүй
Вьетнам улс		Тусгагдаагүй

НҮБ-ЫН ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫН СУУРЬ ЗАРЧМУУД БУСАД УЛС, ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛЬД ТУСГАГДСАН БАЙДЛЫН ЛАВЛАГАА¹

НҮБ-ын бие даасан шүүхийн үндсэн зарчмууд буюу Шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлэх баталгааг хангах ерөнхий зорилгын хүрээнд, Шүүхийн бие даасан байдал, Шүүгчийн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, Шүүгчийн сонгон шалгаруулалт, сургалт, Шүүгчийн албаны бүрэн эрхийн баталгаа, Шүүгчийн мэргэжлийн нууцлал, Сахилгын хариуцлага хүлээлгэх, шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулахтай холбоотой зургаан дэд зарчмуудын задаргаа нийт 20 зарчим нь зарим гадаад улсын Үндсэн хуульд хэрхэн тусгагдсан байдлыг дээрх зургаан дэд зарчмын дагуу системчлэн авч үзлээ.

Харьцуулалтад авч үзсэн улсуудын хувьд НҮБ-ын бие даасан шүүхийн үндсэн зарчмууд батлагдсан 1985 оноос хойш Үндсэн хуулиа батлан мөрдүүлсэн улс орнууд юм. Үүнд, Бүгд найрамдах өмнөд Африк улс, Египет улс, Бүгд найрамдах Хорват улс, Бүгд найрамдах Чех улс, Холбооны бүгд найрамдах ардчилсан Этиоп улс, Украин улс, Унгар улс, Бүгд найрамдах Вьетнам улс хамаарч байна. Эдгээр улсууд нь гол төлөв пост-социалист улс байна.

Нэг. Шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлэхтэй холбоотой зарчмууд /1-7 дугаар зарчим/

1. *Шүүхийн хараат бус байдлыг төрөөс баталгаажуулж, тухайн улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжуудад тусган баталгаажуулж, засгийн газар болон түүний харьяа байгууллагууд шүүхийн хараат бус байдлыг хүндэтгэж, сахин биелүүлнэ.*
2. *Шүүх аливаа хэргийг алагчлалгүйгээр, хэний ч нөлөөнд авталгүйгээр, нотлох баримтад үндэслэн, хуульд нийцүүлэн, хууль бус нөлөөлөл, сэтгэл хөдлөл, дарамт шахалт, сүрдүүлэггүйгээр, шууд болон шууд бус хөндлөнгийн оролцоогүйгээр шийдвэрлэнэ.*
3. *Шүүх нь Хуульд заасан эрх мэдлийн хүрээнд шүүхийн шинж чанар бүхий аливаа асуудал мөн өөрийн хэм хэмжээнд байх бүхий л асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхийг хэрэжүүлнэ.*
4. *Шүүн таслах үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, шүүгчийн гаргасан шийдвэрийг засварлах субъект байх ёсгүй. Энэ зарчим нь шүүхийн хяналтыг хэрэжүүлэх, шүүх эрх мэдлийн эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу шийдвэрийг өөрчлөхөд хамаарахгүй.*
5. *Хүн бүр энгийн шүүх болон дагнасан шүүхээр хуулийн процедур журмын дагуу шүүлгэх эрхтэй. Шүүх нь энгийн болон дагнасан шүүхийн эрх мэдэлд хамаарахгүй хуулийн процедур журмын дагуу хэргийг хянан шийдвэрлэж болохгүй.*

¹ Тус лавлагааг Шүүхийн судалгаа хариуцсан ахлах референт Б.Отгон, судлаач-багш Л.Галбаатар, Ч.Содхүү, гэрээт судлаач Н.Анхбаяр, зочин судлаач Кейт Скарлетт нар гүйцэтгэв.

6. *Шүүхийн байгууллагын хараат бус байдлын талаарх үндсэн зарчим нь шүүхээс шүүн таслах ажиллагаа явуулахдаа талуудын эрхийг хүндэтгэн, эрх тэгш хандах үүрэг юм.*
7. *Гишүүн улс нь шүүхийг үндсэн чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрээр хангах үүрэгтэй.*

Улс орнуудын Үндсэн хуульд шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлэх зарчмын агуулга хангалттай тусгагдсан гэж болно. Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх, шүүх бие даасан байх, шүүхийн үйл ажиллагаанд аливаа этгээд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглох, Шүүх Үндсэн хууль, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах, хүн бүр шударга шүүхээр шүүлгэх эрх зэрэг ерөнхий малгай зарчмууд харьцуулалтад авч үзсэн бүх улсын Үндсэн хуульд тусгалаа олсон байна. Харин Украин, Хорват зэрэг улсын Үндсэн хуульд гэмт хэрэгт буруутгагдаж буй этгээдийн эрхийг баталгаажуулах агуулгаар бие даасан, шударга шүүхийн зарчмуудыг харьцангуй өргөн хүрээнд тусгасан байна.

Харьцуулалтад авч үзсэн улсын Үндсэн хууль тус бүрт Шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлэх зарчмуудын агуулгыг өөртөө агуулсан холбогдох 3-10 зүйл заалт байгаа юм. Гэвч бие даасан шүүхийн оршин тогтнох үндсэн гол нөхцөл болсон шүүхийн төсөв, санхүүгийн асуудалтай холбоотой 7 дугаар зарчмыг харьцуулалтад авагдсан 8 улсын тал хувь нь Үндсэн хуульдаа тусгаагүй байна.

Харин “Шүүхээс шүүхийн процесс ажиллагаа явуулахдаа талуудын эрхийг хүндэтгэн, эрх тэгш хандах, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэн ажиллах үүрэг хүлээн” гэсэн 6 дугаар зарчим судлагдсан улсуудын Үндсэн хуулиудад тусгагдаагүй байна. Энэ нь шүүгч талуудад эрх тэгш, алагчлалгүй хандахтай холбоотой процессын эрх зүйн үндсэн зарчим юм.

Хоёр. Шүүгчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөөтэй холбоотой зарчмууд /8-9 дүгээр зарчим/

8. *Хүний эрхийн түгээмэл тунхаглалын дагуу шүүхийн байгууллагын ажилчид, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч нь бусад иргэний адил үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх, цуглаан хийх эрхтэй ба энэхүү эрхээ эдэлж байгаа шүүгчид нь үргэлж албаны нэр төр, шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хадгална.*
9. *Шүүгчийн мэргэжлийн сургалтыг дэмжих, шүүхийн хараат бус байдлыг хамгаалахын тулд, тэдний ашиг сонирхлыг төлөөлөх шүүгчдийн бүрэлдэхүүнтэй байгууллага болон бусад байгууллага, холбоонд нэгдэх эрхтэй.*

Энэхүү зарчим нь хүний эрхийг хангах, шударга ёсыг тогтоогч шүүгч нь мэргэжлийн өндөр түвшний байх, үүний тулд өндөр түвшний мэргэжлийн шүүгчийг бий болоход туслах, сургах, дэмжих, шүүгчийн хараат бус байдал, мэргэжлийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор дуу хоолойгоо илэрхийлэх, дээрх зорилгоор бусад мэргэжлийн байгууллага, холбоонд элсэх тухай, энэ явцад шүүгчийн хараат

бус байдлаа хэрхэн хадгалах тухай чухал агуулгатай. Гэсэн хэдий ч судлагдсан 8 улсын хувьд аль нь ч Үндсэн хуульдаа дээрх зарчмыг тусгаагүй байна.

Гурав. Шүүгчийн сонгон шалгаруулалт, сургалттай холбоотой зарчим /10 дугаар зарчим/

10. Шүүгчээр сонгогдсон этгээд хувь хүний хувьд шударга, зохих сургалтад хамрагдсан, хуульд заасан мэргэжлийн ур чадвартай байна. Шүүгч сонгон шалгаруулах аливаа арга нь буруу сэдэл, зорилгоор шүүгчийг томилохоос сэргийлсэн байна. Шүүгчийг сонгохдоо арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, яс үндэс, нийгмийн гарал байдал, өмч хөрөнгө, нийгмийн байдал зэрэг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах ёсгүй. Шүүгчид нэр дэвшигч нь тухайн улсын иргэн байх шаардлагыг ялгаварлан гадуурхсан гэж үзэхгүй.

Шүүгч нь хүний эрхийг хангах, шударга ёсыг тогтоогч болох хувьдаа мэргэжлийн өндөр түвшинд байх шаардлага тавигддаг тухай өмнө дурдсан. Үүний тулд шүүгч байнга мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх эрмэлзэлтэй байх ёстой бөгөөд шүүгчийн сургалттай холбоотой энэхүү зарчим дээрх 8 улсын Үндсэн хуульд тусгалаа олоогүй байна. Шүүгчийг сонгон шалгаруулж, томилохтой холбоотой зарчим, шаардлагуудын талаар БНӨАУ, Украин, Чех зэрэг гурван улс л Үндсэн хуульдаа тусгасан байна. Ингэхдээ Чех, Украин улсуудын Үндсэн хуульд шүүгчийг томилохтой холбоотой нас, мэргэжлийн шаардлагуудыг тавьсан бол БНӨАУ-ын Үндсэн хуульд арьс өнгөөр ялгаварлахгүй байх, хүйсийн тэнцвэрийг хадгалах зэрэг ихээхэн дэвшилтэт зарчмыг оруулсан байна. Бусад судлагдсан улсын Үндсэн хуульд энэхүү зарчмууд огт тусгаагдаагүй юм.

Дөрөв. Шүүгчийн албаны бүрэн эрхийн баталгаатай холбоотой; /11-14 дүгээр зарчим/

- 11. Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа, хараат бус, аюулгүй байдал, зохих цалин хөлс, ажлын нөхцөл, тэтгэвэрт гарах насыг хуулиар тусгайлан зохицуулна.*
- 12. Шүүгч томилогдсон, сонгогдсон эсэхээс үл хамааран тэтгэвэрт гарах, бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэл шүүгчийн бүрэн эрхийн хугацаа баталгаатай байна.*
- 13. Шүүгчийг дэмжих буюу дэвшүүлэх тогтолцоо нь бодит хүчин зүйл, эзэмшсэн байх ур чадвар, туршлагад суурилсан байх ёстой.*
- 14. Тухайн шүүх дэх шүүгчдэд хэрэг хуваарилах үйл ажиллагаа нь шүүхийн захиргааны дотоод үйл ажиллагаа байна.*

Улс орнууд шүүгчийн бүрэн эрхийн хугацаа, сонгогдсон эсхүл томилогдсон шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх болон огцруулах үндэслэлүүдийг Үндсэн хуульдаа шууд заах, эсхүл хуулиар зохицуулж болохыг зааж өгсөн нь түгээмэл байна. Түүнчлэн шүүгчийн бүрэн эрхийн баталгаатай холбоотойгоор БНӨАУ-ын Үндсэн хуульд шүүгчийн цалин хөлс, нэмэгдлийг, Этиоп улсын хувьд тэтгэврийн насыг нэмэх асуудлыг зөвхөн хуулиар зохицуулах тухай онцлог заалт байна. Чех

улсын хувьд шүүгчийг өөрийнх нь хүсэл зоригоос гадуур өөр шүүхэд шилжүүлэхийг хориглосон бол Хорват улсын хувьд шүүгч үндэслэлгүйгээр албан тушаалаас чөлөөлөгдсөн тухай гомдлыг Үндсэн хуулийн шүүх харьяалан шийдвэрлэх, түүнчлэн шийдвэрлэх хугацаа зэргийг дэлгэрэнгүй заасан байдаг байна.

Харин Бүгд найрамдах Вьетнам улсын Үндсэн хуульд шүүгчийн бүрэн эрхийн баталгаатай холбоотой 11-14 дүгээр зарчмууд тусгагдаагүй байна.

Харьцуулалтад авч үзсэн 8 улсын аль нь ч Үндсэн хуульдаа шүүгчийн албаны бүрэн эрхийн баталгааг хангах зорилготой Шүүгчийг дэмжих болон дэвшүүлэх тогтолцооны талаарх 13 дугаар зарчим, Хэрэг хуваарилах асуудлыг шүүх дотооддоо шийдэхтэй холбоотой 14 дүгээр зарчмуудыг тусгаагүй байна.

Тав. Мэргэжлийн нууцлал болон дархан эрхтэй холбоотой зарчмууд /15-16 дугаар зарчим/

15.Нээлттэй шүүх хуралдаанаас бусад шүүн таслах ажиллагааны хүрээнд албан үүргийн дагуу олж мэдсэн шүүхийн мэргэжлийн нууцыг задруулахыг хориглох бөгөөд тэрхүү нууцтай холбоотойгоор мэдүүлэг авахыг хориглоно.

16.Үндэсний хуульд заасны дагуу аливаа мэргэжлийн сахилгын үйл ажиллагаа, тухайн улсын нөхөн олговор олгох харилцааг хөндөхгүйгээр шүүгч нь шүүн таслах үйл ажиллагаа явуулсны төлөө мөнгөн хохиролтой холбоотой иргэний нэхэмжлэлээс халдашгүй дархан байна.

Хорват улсын Үндсэн хуульд Шүүгчийн шүүн таслах ажиллагаатай холбогдуулан мэдүүлэг авах, мөрдөн байцаах ажиллагааг Үндэсний шүүхийн зөвлөлийн зөвшөөрөлгүй хийж болохгүй гэж заасан.

Бусад улсын Үндсэн хуульд дээрх зарчмуудыг агуулсан зүйл, заалт тусгагдаагүй байна.

Зургаа. Сахилгын хариуцлага хүлээлгэхтэй холбоотойгоор шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулахтай холбоотой зарчмууд; /17-20 дугаар зарчим/

17.Шүүгчийн мэргэжлийн ур чадвартай холбоотойгоор түүний эсрэг аливаа хэрэг, гомдлын үйл ажиллагааг зохих ёсны процедурын дагуу шударгаар, шуурхай хянан хэлэлцэнэ. Шүүгч нь шударга сонсгол явуулахыг шаардах эрхтэй. Шүүгч өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд хянан шалгах анхдагч үйл ажиллагаа нь нууц байна.

18.Шүүгчийг мэргэжлийн болон зан байдлын хувьд өөрсдийн ажил үүргээ биелүүлж чадахгүй, ажилд тохирохгүй гэх шалтгаанаас өөр бусад шалтгаанаар сахилгын шийтгэл оногдуулж, албан үүргээс нь чөлөөлж болохгүй.

19.Шүүгчийн сахилгын шийтгэл болон албанаас нь түдгэлзүүлэх, огцруулахтай холбогдсон ажиллагаа нь шүүхийн ёс зүйн тогтоосон стандартын дагуу явагдах ёстой.

20. Сахилгын шийтгэл болон албанаас нь түдгэлзүүлэх, ажлаас халах ажиллагаа нь тусгайлсан процедур, журмын дагуу явагдах ёстой. Энэхүү зарчим нь Дээд шүүх болон хууль тогтоох байгууллагын гишүүдийг огцруулах, бусад ижил төстэй ажиллагаанаас гарах шийдвэрт хамаарахгүй.

Харьцуулалтад авч үзсэн улс орнуудын хувьд Сахилгын хариуцлага хүлээлгэхтэй холбоотойгоор шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулах тухай 17-20 дугаар зарчмуудаас Чех, Хорват, БНӨАУ, Украин улсын Үндсэн хуульд тус бүр нэг зарчим тусгагдсан бол Египет, Унгар, Вьетнам, Этиоп улсын Үндсэн хуульд дээрх зарчим огт тусгагдаагүй байна.

Чех улсын Үндсэн хуульд шүүгчид хүлээлгэсэн сахилгын хариуцлага нь дүрэмд заасан үндэслэлтэй, тайлбартай байх ёстой гэж заасан.

Хорват улсын хувьд шүүгчийг огцруулах үндэслэлд шүүгч гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон эсхүл сахилгын ноцтой зөрчил гаргасан нь хамаарч байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор огцруулах шийдвэрийг тухайн шүүгч эс зөвшөөрвөл хэрхэн гомдол гаргах, давж заалдах талаар Үндсэн хуульдаа нарийн зохицуулалт оруулсан байна.

БНӨАУ-ын хувьд зөвхөн шүүгчийг огцруулах процедурыг Үндсэн хуульдаа тусгасан.

Украин улсын Үндсэн хуульд шүүгчийг огцруулах үндэслэлд шүүгч тангаргаа зөрчсөн эсхүл шүүгчид тавигдах шаардлагыг зөрчсөн гэсэн үндэслэлүүдийг зааж өгсөн байна.

-оОо-